


ОЛОН НИЙТЭЭС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

Төрийн банк нь Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлж, системийн нөлөө бүхий банкууд олон нийтэд нээлттэй хувьцаат компани болох үүргийн хэрэгжилтийг ханган 2022 оны 10 дугаар сард Монголын хөрөнгийн биржээр дамжуулан хувьцаагаа олон нийтэд нээлттэй арилжиж, нийт 25.4 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн билээ.

Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын талаар үнэт цаасны танилцуулгад тодорхой тусгасан бөгөөд банкны үндсэн үйл ажиллагааг дэмжих, үүн дотроо Байгаль орчин, нийгэм, засаглалын зарчимд нийцсэн болон Дундаж давхаргыг дэмжсэн зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, зах зээлд нэвтрүүлэхэд дараах байдлаар зарцуулахаар төлөвлөсөн.



Анхдагч зах зээлд хувьцаагаа арилжсанаас хойш буюу 2022 оны 10 дугаар сараас хойш 2023 оны 3 дугаар сарыг дуустал хугацаанд зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, сайжруулах чиглэлд дараах ажлуудыг хийж, шинэ бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нэвтрүүлсэн байна. Үүнд:



"Save green" эмэгтэйчүүдэд аяллын кредит карт

Энэхүү карт нь эмэгтэйчүүдэд зориулсан, ЮнионПэй байгууллагын Travel Mate.Asia хөнгөлөлт урамшуулалд хамрагдах боломж бүхий, нууцлал аюулгүй байдлыг хангасан EMV чиптэй, зайнаас унших Pay-Way технологи бүхий төгрөг болон юанийн валютын сонголттой кредит карт юм. Уг картын хураамжийн орлогоос 10,000 төгрөгийг Улаанбаатар хотод мод тарих үйлсэд зарцуулж, байгаль орчноо хамгаалах, агаарын бохирдлыг бууруулах чиглэлд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.




Өрхийн бизнесийн зээл

Дундаж давхаргын иргэдийг дэмжих зорилгоор тодорхой хугацаанд бичил бизнес буюу жижиглэнгийн худалдаа, өрхийн аж ахуй, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсэн Улаанбаатар хот болон Орон нутгийн иргэдийг Банкны бизнес инкубацын үйлчилгээнд хамруулан санхүүгийн боловсрол, зөвлөгөө мэдээлэл өгөх замаар бизнесээ амжилттай удирдахад тодорхой хэмжээнд сургасны үндсэн дээр өрхийн орлогоо нэмэгдүүлэхэд зориулан олгож буй уян хатан нөхцөлтэй зээлийн бүтээгдэхүүнийг шинээр зах зээлд нэвтрүүллээ.



Гарааны бизнесийн зээл

Улаанбаатар хот болон Орон нутгийн бизнес эрхлэгч иргэн, хуулийн этгээдийг Банкны инкубацын үйлчилгээнд хамруулан үйл ажиллагааны эхлэлийн болон өсөлтийн мөчлөгөөс тогтворжих түвшинд хүрэхэд дэмжлэг үзүүлэн, технологийн шинэчлэлт хийх, тоног төхөөрөмж худалдан авах, шинэчлэх, үндсэн хөрөнгө бэлтгэх зэрэг хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан олгох зээлийн бүтээгдэхүүнийг шинээр зах зээлд нэвтрүүллээ.



Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл

Бизнес эмэгтэйчүүдийн зээлийн бүтээгдэхүүнийхээ нөхцөл, шаардлагыг сайжруулах зорилгоор зээлийн хэмжээ, хугацааг нэмэгдүүлж, зээлдэгчид тавигдах шаардлага болон зээлийн судалгааны аргачлалыг хялбаршуулан бүтээгдэхүүний нөхцөлийг сайжрууллаа.



Боловсролыг дэмжих зээл

“Сургалтын төлбөрийн зээл”-ийн бүтээгдэхүүний нөхцөл, шаардлагыг сайжруулан зээлийн хэмжээ, хугацаа, зориулалтыг нэмэгдүүлж, сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсрол, дээд боловсрол эзэмшихээр суралцаж буй иргэний сургалтын үйл ажиллагааг дэмжин сургалтын төлбөр төлөх, дотуур байрны төлбөр төлөх, сургалтын хэрэглэгдэхүүн худалдан авахад зориулан олгохоор өөрчилж, зээлдэгчид тавигдах шаардлага болон зээлийн судалгааны аргачлалыг өөрчлөн “Боловсролыг дэмжих зээл”-ийн бүтээгдэхүүн гэсэн нэршлээр зах зээлд гаргалаа.

Мөн зах зээлийн нөхцөл байдал, мөнгөний бодлогын хүүний өөрчлөлт, банкны зорилго зорилгод нийцүүлэн зээлийн бусад уламжлалт бүтээгдэхүүн үйлчилгээний хүү шимтгэлийн ерөнхий нөхцөлийг тухай бүр өөрчлөлт оруулан, зээлийн багцын оновчтой удирдлагыг хэрэгжүүлэн, бага болон дундаж орлоготой иргэдэд чиглэсэн зээлийн бүтээгдэхүүнүүдийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхааран ажиллалаа.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтыг зээлийн бүтээгдэхүүнээр харуулбал:

Тогтвортой хөгжилд чиглэсэн бүтээгдэхүүн /Ногоон/	Дундаж давхаргад чиглэсэн бүтээгдэхүүн
Зарцуулсан дүн /сая.төг/ 12,701.3	Зарцуулсан дүн /сая.төг/ 12,792.4
Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл 11,355.0	Өрхийн бизнесийг дэмжих зээл 1,207.2
Эко автомашины зээл 358.5	Гарааны бизнесийн зээл 1,375.9
Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны зээл 863.1	Боловсролыг дэмжих зээл 115.0
“Save green” эмэгтэйчүүдэд зориулсан аяллын кредит карт 124.7	Гялс зээл 490.9
	Цалингийн зээл 5,446.5
	Тэтгэврийн зээл 4,157.0
Нийт дүн: 25,493.7	

Төр засгаас явуулж буй бодлого шийдвэрүүдэд нийцүүлэн Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулах, орон нутгийн иргэд, жижиг дунд аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх чиглэлийг баримталж нийт зарцуулалтын дүнгийн 61 хувь буюу 15.5 тэрбум төгрөгийг орон нутагт олгож татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтыг төлөвлөгөөний дагуу бүрэн зарцууллаа.